

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 263

танай _____-ны № _____-т

Г БУЛГАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.НАМУУНЦЭЦЭГ ТАНАА

Г Өөрчлөлтгүй дүгнэлт 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020364

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,629,306.30	78,663,118.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,637,632.50	60,175,934.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,637,632.50	60,175,934.13
3121	Төгрөг	9,637,632.50	60,175,934.13
31211	Төрийн сангийн харилцах	9,637,632.50	60,175,934.13
33	АВЛАГА	41,445,700.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	41,445,700.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	30,545,973.80	18,487,184.82
351	Түүхий эд материал	2,567,544.82	3,067,544.82
35110	Тусгай зориулалттай материал	1,953,514.82	1,953,514.82
35130	Эм боох материал	614,030.00	1,114,030.00
354	Хангамжийн материал	27,978,428.98	15,419,640.00
35420	Аж ахуйн материал	11,027,827.98	5,210,940.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,205,000.00	1,100,700.00
35460	Хүнсний материал	2,317,601.00	-
35470	Бусад хангамжийн материал	7,428,000.00	9,108,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	497,254,382.44	498,484,322.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	497,254,382.44	498,484,322.80
392	Биет хөрөнгө	491,654,382.40	492,884,322.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	407,625,610.49	407,625,610.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,723,819.68)	(26,298,426.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,060,400.00	37,460,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,700,399.86)	(18,793,733.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,169,039.22	101,718,501.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,386,058.54)	(40,704,633.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,917,605.56	20,398,453.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,152,137.37)	(10,039,780.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	40,809,698.00	40,809,698.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,965,555.42)	(19,291,767.66)
393	Биет бус хөрөнгө	5,600,000.04	5,600,000.04
39301	Програм хангамж	482,000.00	482,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(482,000.00)	(482,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,400,000.00	7,400,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,799,999.96)	(1,799,999.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	578,883,688.74	577,147,441.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	578,883,688.74	577,147,441.75
51	Засгийн газрын хувь оролцоо	578,883,688.74	577,147,441.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,643,326.56	181,643,326.56
51101	Өмч: - төрийн	181,643,326.56	181,643,326.56
512	Хуримтлагдсан үр дүн	156,807,446.93	155,071,199.94
51210	Өмнөх үеийн үр дүн	156,807,446.93	156,570,848.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,499,648.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	240,432,915.25	240,432,915.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	578,883,688.74	577,147,441.75

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	620,613,672.56	480,152,530.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,274,122.56	42,318,120.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,274,122.56	42,318,120.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,274,122.56	42,318,120.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	13,497,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,274,122.56	28,820,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,339,550.00	437,834,410.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,330,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	360,330,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,226,600.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168,780,900.00	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	41,445,700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,249,600.00	19,450,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,249,600.00	19,450,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,532,750.00	418,384,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,532,750.00	418,384,410.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573,816,352.96	481,652,178.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573,816,352.96	481,652,178.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,538,210.96	480,102,522.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,450,848.00	295,683,762.37
210101	Үндсэн цалин	167,680,804.00	209,391,705.66
210102	Нэмэгдэл	123,916,654.00	62,003,716.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,077,000.00	7,728,815.00
210104	Урамшуулал	66,776,390.00	16,559,525.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,402,781.00	41,607,300.00
210201	Тэтгэврийн даатгал	32,025,903.51	30,588,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,380,370.08	2,754,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,721,916.88	2,203,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	661,325.03	550,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,613,265.50	5,509,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,311,458.00	12,900,344.00
210301	Гэрэл, цахилгаан	3,690,478.00	3,121,144.00
210302	Түлш, халаалт	8,325,980.00	9,419,200.00
210303	Цэвэр, бохир ус	295,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,246,128.00	34,858,007.98
210401	Бичиг хэрэг	3,245,400.00	2,779,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,216,290.00	12,574,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,228,800.00	977,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	809,433.00	1,442,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,205.00	2,126,820.00
210408	Бараа материал акталсны зардал	-	14,956,887.98
2105	Нормативт зардал	76,342,848.50	52,780,129.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,430,482.50	27,772,028.00
210502	Хоол, хүнс	20,912,366.00	24,958,101.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	50,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,903,100.00	5,222,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,903,100.00	843,000.00
210604	Урсгал засвар	-	4,379,300.00
2107	Томиллолт, зочны зардал	350,000.00	270,000.00
210702	Дотоод албан томиллолт	350,000.00	270,000.00

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	613,950.00	3,849,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,070,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	152,250.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,700.00	70,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	52,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
210807	Газрын төлбөр	-	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,917,097.46	32,931,579.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	848,247.00	1,261,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,068,850.46	31,670,479.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,278,142.00	1,549,656.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,400,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,878,142.00	1,549,656.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,878,142.00	1,549,656.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	46,797,319.60	(1,499,648.99)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	46,797,319.60	(1,499,648.99)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	556,893,850.00	492,777,710.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	54,943,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	54,943,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	54,943,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	54,943,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	556,893,850.00	437,834,410.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,330,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	360,330,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,780,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168,780,900.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,249,600.00	19,450,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,249,600.00	19,450,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,532,750.00	418,384,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,532,750.00	418,384,410.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	546,276,217.50	442,239,408.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	546,276,217.50	442,239,408.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,998,075.50	440,689,752.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,450,848.00	295,920,360.37
210101	Үндсэн цалин	167,680,804.00	209,628,303.66
210102	Нэмэгдэл	123,916,654.00	62,003,716.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,077,000.00	7,728,815.00
210104	Урамшуулал	66,776,390.00	16,559,525.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,402,781.00	41,607,300.00
210201	Тэтгэврийн даатгал	32,025,903.51	30,588,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,380,370.08	2,754,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,721,916.88	2,203,800.00

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	661,325.03	550,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,613,265.50	5,509,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,371,458.00	12,900,344.00
210301	Гэрэл, цахилгаан	3,690,478.00	3,121,144.00
210302	Түлш, халаалт	8,325,980.00	9,419,200.00
210303	Цэвэр, бохир ус	355,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,894,128.00	19,901,120.00
210401	Бичиг хэрэг	2,949,900.00	2,779,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,216,290.00	12,574,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,228,800.00	977,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,433.00	1,409,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,499,705.00	2,159,820.00
2105	Нормативт зардал	75,811,563.50	52,752,528.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,992,337.50	28,122,028.00
210502	Хоол, хүнс	21,549,226.00	22,640,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,270,000.00	1,990,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,014,500.00	12,227,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,014,500.00	3,427,900.00
210602	Тавилга	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	-	6,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.00	270,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.00	270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	984,950.00	3,849,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,070,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	152,250.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46,700.00	70,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	52,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
210807	Газрын төлбөр	-	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,717,847.00	1,261,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,717,847.00	1,261,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,278,142.00	1,549,656.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,400,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,878,142.00	1,549,656.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,878,142.00	1,549,656.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,617,632.50	50,538,301.63
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	980,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	980,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	980,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	980,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(980,000.00)	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,637,632.50	50,538,301.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,637,632.50

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,637,632.50	60,175,934.13
----	---	--------------	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	110,010,127.33	532,086,369.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	110,010,127.33	532,086,369.14
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	46,797,319.60	46,797,319.60
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	156,807,446.93	578,883,688.74
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	156,807,446.93	578,883,688.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(236,598.00)	(236,598.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	156,570,848.93	578,647,090.74
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,499,648.99)	(1,499,648.99)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	155,071,199.94	577,147,441.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	479,593,500.00	440,689,752.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	479,593,500.00	440,689,752.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,593,500.00	440,689,752.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	333,879,500.00	295,920,360.37
210101	Үндсэн цалин	245,329,800.00	205,758,084.66
210102	Нэмэгдэл	61,666,700.00	62,003,716.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,081,000.00	7,728,815.00
210104	Урамшуулал	21,802,000.00	20,429,744.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,159,700.00	41,607,300.00
210201	Тэтгэврийн даатгал	27,141,000.00	30,588,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,754,700.00	2,754,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,203,800.00	2,203,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	550,800.00	550,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,509,400.00	5,509,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,450,000.00	12,900,344.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	3,121,144.00
210302	Түлш, халаалт	9,890,000.00	9,419,200.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,996,900.00	19,901,120.00
210401	Бичиг хэрэг	2,779,700.00	2,779,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,574,100.00	12,574,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,177,200.00	977,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,416,900.00	1,409,700.00

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,049,000.00	2,159,820.00
2105	Нормативт зардал	53,944,700.00	52,752,528.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,304,200.00	28,122,028.00
210502	Хоол, хүнс	22,640,500.00	22,640,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,990,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,200,000.00	12,227,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,400,000.00	3,427,900.00
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	6,800,000.00	6,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	270,000.00	270,000.00
210702	Дотоод албан томилолт	270,000.00	270,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,431,600.00	3,849,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,070,000.00	2,070,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	299,700.00	96,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	70,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,200.00	52,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	207,200.00	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	472,500.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,100.00	1,261,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,100.00	1,261,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	479,593,500.00	491,228,054.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,450,000.00	17,900,344.00
122005	Орон нутгийн төсвөөс	19,450,000.00	17,900,344.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	54,943,300.00	54,943,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,943,300.00	54,943,300.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	405,200,200.00	418,384,410.00
122001	Хандив тусламж /дотоод/	405,200,200.00	418,384,410.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,637,632.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	60,175,934.13

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Зорилго: Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.7 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,637.6	60,175.9	50,538.3
Авлага	41,445.7	-	(41,445.7)
Бараа материал	30,546.0	18,487.2	(12,058.8)
Үндсэн хөрөнгө	497,254.4	498,484.3	1,229.9
Нийт хөрөнгө	578,883.7	577,147.4	(1,736.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	578,883.7	577,147.4	(1,736.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	578,883.7	577,147.4	(1,736.2)

Мөнгөн хөрөнгийн данс 60.1 сая төгрөг болж 50.5 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжилттэй холбоотой зарцуулаагүй үлдэгдэл болно.

Авлагын үлдэгдэл 41.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагын бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 18.4 сая төгрөг болж 12.1 сая төгрөгөөр буурахад хангамжийн материалын зарцуулалт гол нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд бараа материал данс 50.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 62.3 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 498.5 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийг 32.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэсэн, 31.7 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 577.1 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр буурсан нь тайланд хугацааны алдагдалтай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 418.3 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 54.9 сая төгрөг, нийт зарлагыг 422.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 473.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 418.3 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 418.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 54.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 422.7 сая төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлын төсвийг 34.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1.3 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэлээр нь зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудит менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 573.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 443.0 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 3 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна, хэрэгжилт 100 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	236.5	1	236.5	100%
Албан шаардлага	3	464,404.7	3	464,404.7	100%
Нийт дүн	4	464,641.2	4	464,641.2	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 450.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 448.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүй 1,687,500 төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:”, 1.2.1-д “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төв нь 5.6 сая төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЭМТ-ийн даргад урамшуулал олгосон бөгөөд сумын засаг даргын захирамж гаргуулаагүй.	1	1,687.5	1	1,687.5								
Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн төлбөрт цахим төлбөрийн баримт шивүүлээгүй	1	5,596.9			1	5,596.9						
Дүн	2	7,284.4	1	1,687.5	1	5,596.9	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 40 мэдээ хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг мэдээлээгүй.	1	443,001.2			1	443,001.2		
	0	-						
Дүн	1	443,001.2	0	-	1	443,001.2	0	-